

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Статистикийн хэлтсийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2023/03/НА-СТА-ТЗШ

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Мөрөн сум 2023 он</p>	<p>Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар Утас:88883317 Цахим хаяг: Erdenebaatara@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр Утас: 99089114 Цахим хаяг: Tegshdelgerb@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: Б.Давааням Утас: 88095436 Цахим хаяг: Davaanyamb@audit.gov.mn</p> <p>Аудитор: Г.Ичинхорлоо Утас: 88688168 Цахим хаяг: lchinkhorloog@audit.gov.mn</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	4
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	10
4. АУДИТЫН ТАЙЛАН	13
4.1 Ерөнхий зүйл	13
4.2 Материаллаг байдал	13
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	13
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	14
4.5.1 Завсрын аудитын талаар	15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	15
5.1 Албан шаардлага	16
5.3 Зөвлөмж	16
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	17

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
МУЕП	Монгол Улсын Ерөнхий Прокурор



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2023.08.24 № 01/104
танай _____-ны № _____-т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН СТАТИСТИКИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА Б.БАЗАРДАМБУУ
ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Статистикийн хэлтсийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөвсгөл аймгийн Статистикийн хэлтсийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Үндэсний Статистикийн хорооны шийдвэрээр улс орон даяар 10 жилд нэг удаа явагддаг хөдөө аж ахуйн тооллого зохион байгуулагдаж, улсын төсвөөс 104,859.9 мянган төгрөг зарцуулсан байна.

Аудитын гол асуудал

Хөвсгөл аймгийн Статистикийн хэлтэс нь 2022 оны санхүүгийн тайланг хуулийн хугацаа хоцроож ирүүлсэн бөгөөд нягтлан бодогчийн орон тоо байхгүйгээс шалтгаалан байгууллагын албан хаагчаар хавсран гүйцэтгүүлж байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг 2 зорилт, 14 арга хэмжээний хүрээнд 96.8 хувийн биелэлттэй ажилласан гэж дүгнэсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,437,087.00	1,599,987.00
35	БАРАА МАТЕРИАЛ	1,437,087.00	1,599,987.00
354	Хангамжийн материал	1,437,087.00	1,599,987.00
35410	Бичиг хэргийн материал	861,000.00	827,000.00
35420	Аж ахуйн материал	301,600.00	368,700.00
35470	Бусад хангамжийн материал	274,487.00	404,287.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	29,806,117.84	133,905,591.73
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	29,806,117.84	133,905,591.73
392	Биет хөрөнгө	29,806,117.84	133,905,591.73
39203	Авто-тээврийн хэрэгсэл	23,875,000.00	82,500,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-23,875,000.00	-7,499,999.98
39205	Машин тоног төхөөрөмж компьютер)	41,638,459.00	73,518,647.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-12,903,341.16	-18,032,140.40
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	4,053,700.00	9,019,000.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-2,982,700.00	-5,599,914.89
39301	Програм хангамж	450,000.00	450,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-450,000.00	-450,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	31,243,204.84	135,505,578.73
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	00.00	599,080.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	599,080.00
413	Өглөг	00.00	599,080.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	00.00	599,080.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	31,243,204.84	134,906,498.73
51	Засгийн газрын хувь оролцоо	31,243,204.84	134,906,498.73
512	Хуримтлагдсан үр дүн	31,243,204.84	134,906,498.73
51210	Өмнөх үеийн үр дүн	31,243,204.84	31,243,204.84
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	103,663,293.89
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	31,243,204.84	135,505,578.73

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	255,440,796.00	503,170,266.11
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	9,103,400.00	114,039,773.11
120	Нийтлэг татварын бус орлого	9,103,400.00	114,039,773.11
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	9,103,400.00	114,039,773.11
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	9,103,400.00	114,039,773.11
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	246,337,396.00	389,130,493.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	112,340,200.00	119,800,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	112,340,200.00	119,800,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	133,997,196.00	269,329,993.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,000,000.00	5,000,000.00

131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	128,917,196.00	264,329,993.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	80,000.00	00.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	260,682,778.35	399,506,972.22
21	УРСГАЛ ЗАРДАЛ	260,682,778.35	399,506,972.22
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	259,551,038.96	398,937,282.48
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	95,215,005.38	103,726,998.10
210101	Үндсэн цалин	73,032,530.55	75,486,747.91
210102	Нэмэгдэл	18,805,892.63	19,499,013.39
210103	Унаа хоолны хөнгөлөлт	459,000.00	3,903,000.00
210104	Урамшуулал	2,917,582.20	4,838,236.80
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	12,384,155.23	12,691,556.16
210201	Тэтгэврийн даатгал	8,565,939.54	8,630,258.32
210202	Тэтгэмжийн даатгал	954,553.80	1,015,324.38
210203	ҮОМШӨ-ний даатгал	763,642.23	812,259.62
210204	Ажилгүйдлийн даатгал	190,910.74	203,064.81
210205	Эрүүл мэндийн даатгал	1,909,108.92	2,030,649.03
2104	Хангамж, бараа материалын зардал	2,518,600.00	1,419,683.00
210401	Бичиг хэрэг	1,204,910.00	634,100.00
210402	Тээвэр, шатахуун	521,600.00	00.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	361,890.00	660,583.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	430,200.00	125,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	142,990,282.00	271,019,646.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	142,238,882.00	270,157,573.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	00.00	309,273.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	24,700.00	00.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	726,700.00	552,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,442,996.35	10,079,399.22
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	165,600.00	139,100.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	6,277,396.35	9,940,299.22
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,131,739.39	569,689.74
2132	Бусад урсгал шилжүүлэг	196,800.00	182,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	196,800.00	182,400.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	934,939.39	387,289.74
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	934,939.39	387,289.74
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-5,241,982.35	103,663,293.89
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	358,000.16	00.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	358,000.16	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-358,000.16	00.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-5,599,982.51	103,663,293.89

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	251,645,382.00	389,130,493.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	251,645,382.00	389,130,493.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	112,340,200.00	119,800,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	112,340,200.00	119,800,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	139,305,182.00	269,329,993.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,000,000.00	5,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	128,917,196.00	264,329,993.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	5,387,986.00	00.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	251,645,382.00	389,130,493.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	251,645,382.00	389,130,493.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	250,513,642.61	388,560,803.26
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	95,215,005.38	103,726,998.10
210101	Үндсэн цалин	73,032,530.55	75,486,747.91
210102	Нэмэгдэл	18,805,892.63	19,499,013.39
210103	Унаа хоолны хөнгөлөлт	459,000.00	3,903,000.00
210104	Урамшуулал	2,917,582.20	4,838,236.80
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	12,384,155.23	12,691,556.16
210201	Тэтгэврийн даатгал	8,565,939.54	8,630,258.32
210202	Тэтгэмжийн даатгал	954,553.80	1,015,324.38
210203	ҮОМШӨ-ний даатгал	763,642.23	812,259.62
210204	Ажилгүйдлийн даатгал	190,910.74	203,064.81
210205	Эрүүл мэндийн даатгал	1,909,108.92	2,030,649.03
2104	Хангамж, бараа материалын зардал	2,518,600.00	1,665,083.00
210401	Бичиг хэрэг	1,204,910.00	634,100.00
210402	Тээвэр, шатахуун	521,600.00	00.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	361,890.00	660,583.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	430,200.00	370,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	140,230,282.00	270,338,066.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	139,478,882.00	269,475,993.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	00.00	309,273.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	24,700.00	00.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	726,700.00	552,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	165,600.00	139,100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	165,600.00	139,100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,131,739.39	569,689.74
2132	Бусад урсгал шилжүүлэг	196,800.00	182,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	196,800.00	182,400.00

2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	934,939.39	387,289.74
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	934,939.39	387,289.74
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/Төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	00.00	00.00
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	31,243,204.84	31,243,204.84
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	31,243,204.84	31,243,204.84
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	00.00	31,243,204.84	31,243,204.84
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	103,663,293.89	103,663,293.89
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	134,906,498.73	134,906,498.73

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	119,800,500.0	119,413,210.3	387,289.7	99.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	119,800,500.0	119,413,210.3	387,289.7	99.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	119,603,700.0	119,230,810.3	372,889.7	99.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	103,765,300.0	103,726,998.1	38,301.9	100.0
210101	Үндсэн цалин	73,474,200.0	75,486,747.9	-2,012,547.9	102.7
210102	Нэмэгдэл	19,785,600.0	19,499,013.4	286,586.6	98.6
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,342,400.0	3,903,000.0	1,439,400.0	73.1
210104	Урамшуулал	5,163,100.0	4,838,236.8	324,863.2	93.7

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	12,970,700.0	12,691,556.2	279,143.8	97.8
210201	Тэтгэврийн даатгал	8,820,100.0	8,630,258.3	189,841.7	97.8
210202	Тэтгэмжийн даатгал	1,037,700.0	1,015,324.4	22,375.6	97.8
210203	ҮОМШӨ-ний даатгал	830,100.0	812,259.6	17,840.4	97.9
210204	Ажилгүйдлийн даатгал	207,500.0	203,064.8	4,435.2	97.9
210205	Эрүүл мэндийн даатгал	2,075,300.0	2,030,649.0	44,651.0	97.8
2104	Хангамж, бараа материалын зардал	1,665,100.0	1,665,083.0	17.0	100.0
210401	Бичиг хэрэг	216,100.0	634,100.0	-418,000.0	293.4
210402	Тээвэр, шатахуун	603,600.0	00.0	603,600.0	00.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	475,000.0	660,583.0	-185,583.0	139.1
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	370,400.0	370,400.0	00.0	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,063,500.0	1,008,073.0	55,427.0	94.8
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	146,000.0	146,000.0	00.0	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	314,700.0	309,273.0	5,427.0	98.3
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	50,000.0	00.0	50,000.0	00.0
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	552,800.0	552,800.0	00.0	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	139,100.0	139,100.0	00.0	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	139,100.0	139,100.0	00.0	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	196,800.0	182,400.0	14,400.0	92.7
2132	Бусад урсгал шилжүүлэг	196,800.0	182,400.0	14,400.0	92.7
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	196,800.0	182,400.0	14,400.0	92.7
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	119,800,500.0	119,413,210.3	387,289.7	99.7
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	119,800,500.0	119,413,210.3	387,289.7	99.7
131001	Улсын төсвөөс санхүүжих	119,800,500.0	119,413,210.3	387,289.7	99.7
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	08.00	08.00	00.00	100.0
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	00.00	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	07.00	07.00	00.00	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	269,329,993.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	269,329,993.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	269,329,993.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	269,329,993.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	269,329,993.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	269,329,993.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	269,329,993.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,000,000.00

131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	264,329,993.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	00.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Статистикийн хэлтэс нь Монгол Улсын статистик мэдээллийг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр эрхлэн гаргаж, хэрэглэгчдэд адил тэгш үйлчлэх зорилгын хүрээнд статистикийн бүртгэл хөтлөх, мэдээлэл гаргах, дамжуулах, нэгтгэн боловсруулах, тооллого судалгаа явуулах, мэдээлэл судалгааны үр дүнг хэрэглэгчдэд тархаах, мэдээллийн үнэн зөв байдлыг хангах, мэдээллийн сан байгуулах, хадгалах зэрэг статистикийн үйл ажиллагааг явуулдаг байгууллага юм.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар: Хөвсгөл аймгийн Статистикийн хэлтэс нь үйл ажиллагаандаа дараах хууль эрх зүйн орчныг мөрдлөг болгон ажиллаж байна.

- Төрийн аудитын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Статистикийн тухай хууль
- Татварын багц хуулиуд
- Нийгмийн даатгалын тухай хууль
- Хувь хүний нууцын тухай хууль
- Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль гэх мэт бусад хууль тогтоомжууд.

Тайлант онд байгууллагад мөрдөгдөх дараах хууль тогтоомжуудад өөрчлөлт орсон байна. Тухайлбал:

1. Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга 2022 оны 1 дүгээр сарын 1-ээс хэрэгжиж эхэлсэн.
2. Төрийн бүх шатны байгууллага, нийтийн алба, тэдгээрийн үйл ажиллагаанд санхүүгийн сахилга бат мөрдүүлж, ил тод байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлыг хязгаарлах хяналт тавихад чиглэсэн “Төрийн хэмнэлтийн тухай” хууль хэрэгжиж эхэлсэн.
3. Засгийн газрын 2022 оны 107 дугаар тогтоолоор төрийн үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоосон ба 2022 оны 192 дугаар тогтоолоор эрүүл мэндийн салбараас бусад төрийн үйлчилгээний байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын цалингийн доод хэмжээг өөрчлөн тогтоосон байна.

Байгууллагын дотоод хяналтын талаар: Хөвсгөл аймгийн Статистикийн хэлтсийн даргын тушаалаар дотоод хяналтын нэгжийг 3 хүний бүрэлдэхүүнтэй томилсон байна. 2022 онд санхүүгийн үйл ажиллагаа болон албан хэрэг хөтлөлт, албан ёсны мэдээ тайлангийн дамжуулалтын үйл ажиллагааг хамруулан дотоод хяналтыг хэрэгжүүлж, алдаа зөрчилтэй 3 асуудалд заавар зөвлөгөө өгч, алдааг залруулж ажилласан байна.

Харин санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналтын 1, 2-р үе шатны хяналтыг хангалттай хэрэгжүүлж чадахгүй байна гэж үзлээ. **Тухайлбал:** Санхүүгийн үйл ажиллагаанд гүйцэтгэх

удирдлага буюу дарга 1 дүгээр гарын үсэг, нягтлан бодогч 2 дугаар гарын үсэг зурахдаа анхан шатны баримтын бүрдэлд тавих хяналт сул, баримтын эмх цэгц муу, санхүүгийн тайланг хугацаа хоцроож ирүүлсэн зэрэг асуудал нь төсвийн шууд захирагчийн хяналт хангалтгүй байна гэж үзэх үндэслэл болсон.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөө багатай байна гэж үзлээ.

Дотоод аудитын нэгжийн чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хөвсгөл аймгийн Статистикийн хэлтсийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Үндэсний Статистикийн Хорооны 2015 оны 01 дүгээр сарын 29-ны өдрийн А/11 дүгээр тушаалаар баталсан НББ-ийн бодлогын баримт бичгийг мөрдлөг болгон ажиллаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Хөвсгөл аймгийн Статистикийн хэлтсийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 104,262.4 мянган төгрөгөөр буюу 4.3 дахин өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	-	-	-
Бараа материал	1,437.1	1,600.0	162.9
Үндсэн хөрөнгө	29,806.1	133,905.6	104,099.5
Нийт хөрөнгө	31,243.2	135,505.6	104,262.4
Өр төлбөр	-	599.1	-599.1
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	31,243.2	134,906.5	103,663.3
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	31,243.2	135,505.6	104,262.4

Дээрх хүснэгтээс харахад бараа материал дансны үлдэгдэл өмнөх оноос 162.9 мянган төгрөгөөр, үндсэн хөрөнгө 104,099.5 мянган төгрөгөөр тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Энэ нь Үндэсний Статистикийн Хорооноос өрхийн нийгэм эдийн засгийн судалгаанд ашиглагдах автомашин, албан хаагчдын ажиллах орчин нөхцөлийг сайжруулах зорилгоор компьютер тоног төхөөрөмж, тавилга эд хогшлыг үнэ төлбөргүй шилжүүлэн өгсөнтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 187,044.6 мянга, нийт зарлагыг 187,044.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас улсын төсвөөс санхүүжүүлэх дүнг 73,005.2 мянган төгрөгөөр бууруулж, 114,039.4 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь дотоод албан томилолт, урсгал засвар, тээвэр шатахууны зардлыг бодитой тооцоогүйгээс шалтгаалсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны төсвийг 5,761.1 мянган төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 119,800.5 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 119,413.2 мянган төгрөг буюу 99.7 хувьтай байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/						
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	70405-Албан ёсны статистик	80101-Үндсэн үйл ажиллагааны зардал	119,800.5	119,413.2	387.3	99.7%
Нийт дүн			119,800.5	119,413.2	387.3	99.7%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд Үндэсний Статистикийн хорооноос нэмэлт санхүүжилтээр 264,330.0 мянган төгрөгийн санхүүжилт авч Хөдөө аж ахуйн тооллого болон бусад судалгааны ажилд зориулалтын дагуу зарцуулсан байна.

Мөн ЗДТГ-н мал тооллогын зардлаас 5,000.0 мянган төгрөгийн санхүүжилт олгосноос мал тооллогын хяналтаар сумдад ажиллахад шатахуунд 2,056.0 мянган төгрөг, томилолтод 2,944.0 мянган төгрөг тус тус зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

2022 онд гадаад, дотоодын эх үүсвэрээр ямар нэгэн төсөл хөтөлбөр хэрэгжээгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Хөвсгөл аймгийн Статистикийн хэлтсийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах төсвийн зарцуулалттай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Давааням, аудитор Г.Ичинхорлоо нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Тэгшдэлгэр, газрын захирал, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Хөвсгөл аймгийн Статистикийн хэлтсийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 01/16 дугаар албан бичгээр 2023 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг "Дунд" гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 111,034.7 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 2,220.7 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн авч хэрэгжүүлэх арга хэмжээний нийт 29 асуудлаар хяналтыг хэрэгжүүлэхэд дараах зөрчилтэй асуудал илэрлээ. Үүнд:

Нэмэлт санхүүжилтийн данснаас 7,664.0 мянган төгрөгийн сургалтын хоолны зардлыг санхүүжүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5¹ дахь заалт, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.3² дахь заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Дээрх зөрчил нь МУЕА-ын 2021 оны 95 дугаар тушаалын дагуу албан шаардлага хүргүүлэх зөрчил бөгөөд Үндэсний статистикийн хорооноос тооллогын зардал батлахдаа сургалтын хоолны зардал гэж баталсан байна. Иймд Төсвийн шууд захирагчид зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

¹ "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах"

² "сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх;"

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Хөвсгөл аймгийн Статистикийн хэлтсийн 2022 оны Шилэн дансны нэгдсэн цахим хуудасны мэдээллээс дараах мэдээллийг түүвэрлэн шалгалаа. Үүнд:

- Тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл
- Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ
- Төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн мэдээлэл

Шилэн дансны дансны тухай хуулийн хэрэгжилтийг хянаж үзэхэд мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлж ажилласан бөгөөд алдаа зөрчилтэй асуудал илрээгүй.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Төсвийн тухай хууль:

2022 оны Санхүүгийн тайланг хуулийн хугацаа хоцроож ирүүлсэн.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1³ дэх заалтыг зөрчсөн ба Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлсэн.

Нягтдан бодох бүртгэлийн тухай хууль:

1. 12 дугаар сарын шатахууны анхан шатны баримтыг шалгаж үзэхэд 1,754.5 мянган төгрөгийн шатахууны анхан шатны баримтыг дутуу бүрдүүлсэн байна.
Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7⁴ дахь заалтыг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн нь: Зөвлөмж хүргүүлсэн.

2. Нягтлан бодогчийн албан тушаалын тодорхойлолтод 2-оос доошгүй жил ажилласан туршлагатай байх гэж заасан боловч өмнө ажиллаж байсан туршлагагүй, мэргэжлийн бус нягтлан бодогч ажиллуулж байна.
Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3⁵ дахь заалтыг зөрчсөн, байгууллагын нягтлан бодогчийн албан тушаалын тодорхойлолтын туршлагын шалгуурт нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөвлөмж хүргүүлсэн.

³ төсвийн шууд захирагч улирлын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа улирлын эхний сарын 15-ны дотор гаргаж харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн санхүүгийн тайланг 02 дугаар сарын 25-ны дотор харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэх

⁴ Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.

⁵ "Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийг хөтөлж, санхүүгийн тайланг гаргаж, тайлагнах этгээд нь мэргэжлийн, эсхүл мэргэшсэн нягтлан бодогч байна."

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Хөвсгөл аймгийн Статистикийн хэлтсийн 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд завсрын аудит хэрэгжүүлээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар шатахууны зарцуулалтыг нормоор тооцох тухай болон шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой 30,600.0 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгсөн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага					
Зөвлөмж	2	30,600.0	2	30,600.0	100%
Нийт дүн	2	30,600.0	2	30,600.0	100%

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 9,418.5 мянган төгрөгийн зөрчил⁶ илэрснээс, Төсвийн тухай хууль зөрчсөн 1 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 9,418.5 мянган төгрөгийн 3 зөрчилд 3 зөвлөмж өгсөн.

5.1 Албан шаардлага

2022 оны Санхүүгийн тайланг хуулийн хугацаа хоцроож ирүүлсэн.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1⁷ дэх заалтыг зөрчсөн ба Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлсэн.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Төсвийн зарцуулалттай холбоотой асуудал

Илрүүлэлт: 12 дугаар сарын шатахууны анхан шатны баримтыг шалгаж үзэхэд 1,754.5 мянган төгрөгийн шатахууны анхан шатны баримтыг дутуу бүрдүүлсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7⁸ дахь заалтыг зөрчиж байна.

Өгсөн зөвлөмж: Анхан шатны баримтын бүрдэл дутуу ажил гүйлгээг санхүүжүүлэхгүй байх.

Илрүүлэлт: Нэмэлт санхүүжилтийн данснаас 7,664.0 мянган төгрөгийн сургалтын хоолны зардлыг санхүүжүүлсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5⁹ дахь заалт, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.3¹⁰ дахь заалтыг тус тус зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах. Төсвийг зориулалтын дагуу зарцуулах.

1. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуультай холбоотой асуудал

Илрүүлэлт: Нягтлан бодогчийн албан тушаалын тодорхойлолтод 2-оос доошгүй жил ажилласан туршлагатай байх гэж заасан боловч өмнө ажиллаж байсан туршлагагүй, мэргэжлийн бус нягтлан бодогч ажиллуулж байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3¹¹ дахь заалтыг зөрчсөн, байгууллагын нягтлан бодогчийн албан тушаалын тодорхойлолтын туршлагын шалгуурт нийцэхгүй байна

Өгсөн зөвлөмж: Нягтлан бодогчийн орон тоотой болох талаар санал хүргүүлэх, цаашид нягтлан бодогчийг мэргэжлийн сургалтад хамруулж, мэдлэг чадварыг дээшлүүлэх арга хэмжээг авч ажиллах

⁶ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

⁷ төсвийн шууд захирагч улирлын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа улирлын эхний сарын 15-ны дотор гаргаж харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн санхүүгийн тайланг 02 дугаар сарын 25-ны дотор харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэх

⁸ Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.

⁹ "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах"

¹⁰ "сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх;"

¹¹ "Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийг хөтөлж, санхүүгийн тайланг гаргаж, тайлагнах этгээд нь мэргэжлийн, эсхүл мэргэшсэн нягтлан бодогч байна."

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 09 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/ Үүнээс							
			Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Санхүүгийн тайлан хоцроосон	1	0	1	0			1	1		
Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжүүлж ажиллаагүй	1	7,664.0			1	7,664.0				
Анхан шатны баримтын бүрдэл дутуу	1	1,754.5			1	1,754.5				
Өмнө ажиллаж байсан туршлагагүй, мэргэжлийн бус нягтлан бодогч ажиллуулж байна.	1	0			1	0				
Дүн	4	9,418.5	1	0	3	9,418.5	1	1		

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

АХЛАХ АУДИТОР

БАТАЛГААЖУУЛСАН:

АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР ОГНОО:

Б.ТЭГШДЭЛГЭР ОГНОО:

Б.ДАВААНЯМ ОГНОО:

Г.ИЧИНХОРЛОО ОГНОО: *Г.Ичинхорлоо*

117



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 02 сарын 24 өдөр

№ 16/АЭТОНБЗ/ХАА-2023/03
/НАА-СТА-ТШЗ

Мөрөн сум

Хариуцлага тооцуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Хөвсгөл аймгийн Статистикийн хэлтсийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Хөвсгөл аймгийн Статистикийн хэлтсийн нягтлан бодогч нь 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хуульд заасан цаглаварт хугацааг хоцроож 2023 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр аудитын байгууллагад ирүүлсэн байна.

Дээрх зөрчил нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1."төсвийн шууд захирагч улирлын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа улирлын эхний сарын 15-ны дотор гаргаж харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн санхүүгийн тайланг 02 дугаар сарын 25-ны дотор харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэх" гэсэн заалтыг зөрчсөн бөгөөд "Эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3 "Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.2-д "Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд Сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүлнэ" гэсэн заалтуудыг үндэслэн

ШААРДАХ нь:

1. Хөвсгөл аймгийн Статистикийн хэлтсийн нягтлан бодогч О.Бадамгаравт хуульд заасны дагуу хариуцлага тооцож, биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт¹ ирүүлэхийг Хөвсгөл аймгийн Статистикийн хэлтсийн дарга Б.Базардамбууд даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

АУДИТОР:

А.ЭРДЭНЭБААТАР

Г.ИЧИНХОРЛОО



¹ Хөвсгөл аймаг, Мөрөн сум 8-р баг, аймгийн Засаг даргын Тамгын газрын байрны 3 дугаар давхар, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар 302 тоот, Утас: 7038-4043